

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ᠤᠨᠳᠡᠰᠨᠢᠶᠢᠨᠠᠭᠤᠳᠢᠲᠤᠨᠭᠠᠰᠢᠷᠢᠨ
ᠬᠠᠷᠢᠶ᠋ᠠᠭᠠᠬᠣᠪᠳᠠᠬᠤᠠᠶᠢᠮᠠᠭᠳᠠᠬᠤ
ᠲᠥᠷᠢᠶᠢᠨᠠᠭᠤᠳᠢᠲᠤᠨᠭᠠᠰᠠᠷ

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Ховд хот

2020 он

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.....	3
ХОЁР. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР.....	4
ГУРАВ. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР.....	7
ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЛААР.....	9
ТАВ. НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЛААР	13
ЗУРГАА. ДОТООД АЖЛЫН ТАЛААР.....	16
ДОЛОО. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР	18
НАЙМ. ДҮГНЭЛТ, САНАЛ.....	19
ХАВСРАЛТУУД.....	20

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:

Ховд аймгийн Төрийн аудитын газрын 2020 оны үйл ажиллагааны тайланг та бүхэнд өргөн толилуулж байна.

Төрийн аудитын газар УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/100 тоот тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төсвийн болон Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд улс, орон нутгийн төсөвт, төрийн өмчит байгууллагуудын 2019 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийг үндэслэн аудитын газрын 2020 оны жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан гүйцэтгэл, нийцлийн аудитыг хугацаанд нь гүйцэтгэж аудитын үр өгөөжийг дээшлүүлэх, аудиторчуудын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, нотлох баримтын бүрдэлтийг сайжруулах талаар сургалтуудад хамрагдаж, бүх шатны төсвийн захирагч нартай уулзалт зохион байгуулж алдаа зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгч гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллалаа.

Төрийн аудитын газрын 2020 оны үндсэн үйл ажиллагаа, түүний үр дүнг тоон үзүүлэлтээр товч харуулбал,

- Төрийн аудитын газар нь санхүүгийн 239, гүйцэтгэлийн 6, нийцлийн 7, нийт 252 аудит хийж гүйцэтгэжээ.
- Аудитаар 50117.0 сая төгрөгийн 817 алдаа, зөрчил илрүүлж үүнээс 13099.9 сая төгрөгийн 186 алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, залруулагдаагүй зөрчлийг арилгуулахаар 323.9 сая төгрөгийн 54 төлбөрийн акт тогтоож, 28579.5 сая төгрөгийн зөрчил арилгуулах 65 албан шаардлага бичиж, 7412.9 сая төгрөгийн 498 зөвлөмж өгөгдсөн байна.
- Өмнөх оны төлбөрийн актын үлдэгдэл 346.7 сая төгрөг байсан бол 2020 онд 323.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, тайлант онд 315.7 сая төгрөгийн актыг төлбөрийг барагдуулж, 229.4 сая төгрөгийн 12 актыг хууль хяналтын байгууллагуудад шалгуулахаар шилжүүлж, журмын дагуу 56.5 сая төгрөгийн акт хүчингүй болгож, оны эцэст 16 төлбөрийн актын 69.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Актын төлбөрийн биелэлт 90 хувьд хүрч 171.5 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт, 144.3 сая төгрөгийг байгууллага, хувь хүмүүст буцаан олгосон үр дүнтэй байна.
- Мөн 28579.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах 65 албан шаардлага өгч, тайлант онд тогтоосон болон өмнөх оны үлдэгдлээс 30316.7 сая төгрөгийн зөрчлийг арилгаж биелэлт 92 хувьтай байна.
- Тайлант онд нийт 498 зөвлөмжийн өгсний 36.7 хувийг бүртгэл, тайлагнал, 24.6 хувийг орон нутгийн төсийн төлөвлөлтэй, 8.6 хувийг арвилан хэмнэх, үр ашиг, үр нөлөөг сайжруулах, 17.6 хувийг дотоод хяналтыг сайжруулахтай, 12.5 хувийг бусад асуудлаар өгсөн зөвлөмж эзэлж байна. 2020 оны эцсийн байдлаар нийт зөвлөмжийн хэрэгжилт 94 хувьтай байна.
- Өмнө онуудад 7586.1 сая төгрөгийн 12 зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн бол тайланд онд 700.8 сая төгрөгийн зөрчил бүхий 14 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 99.6 сая төгрөгийн 3 асуудал бүрэн шийдвэрлэгдэж, 3808.1 сая төгрөгийн 6 асуудал хэрэгсэхгүй болж, 4379.2 сая төгрөгийн 17 асуудал шалгагдах шатанд байна.

- Төрийн аудитын газар гүйцэтгэсэн нийт аудитын хүрээнд 22.7 тэрбум төгрөгийн үр өгөөжийг шалгагдагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлж 2020 оны нэг төгрөгт ногдох үр өгөөж 49.75 төгрөг болж өмнөх оноос 2 төгрөг 59 мөнгөөр өсөж, нийт дүнгээр 8346.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

ХОЁР. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Төрийн аудитын газар нь 2020 оныг “Төрийн аудитын байгууллагын эрх зүйн орчин, стандартын шинэтгэлийн жил” зорилтын хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, нийт 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитын 3 багийн зохион байгуулалттайгаар төлөвлөгөөнд тусгагдсан зорилтоо бүрэн хэрэгжүүлэн ажиллаа.

Аудиторуудын 10 нь нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, 1 аудитор эрх зүйч–нягтлан бодогч, үүнээс эдийн засгийн ухааны доктор 1, санхүү бизнесийн удирдлагын магистр 6, Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч 8 ажиллаж, нийт ажиллагсдын дундаж нас 46, төрийн албанд мэргэжлээрээ 8-37 жил ажилласан дадлага туршлагатай боловсон хүчин ажиллаж байна.



Дарга, тэргүүлэх аудиторын дэргэдэх зөвлөлийн хурлыг 17 удаа хийж 25 асуудал хэлэлцэн шийдвэр гарган мөрдөн ажилласан ба хамт олны шуурхай зөвлөгөөнийг 21 удаа хийж цаг үеийн ажлуудыг хэлэлцэн үүрэг чиглэлээр хангаж ажиллав.

МУЕА-ын 01 тоот албан даалгавар болон Үндэсний аудитын газраас албан бичиг, цахим хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь хэрэгжүүлэн ажиллав.

Ховд аймгийн ИТХ, тэргүүлэгчдийн хуралдаан, Засаг даргын зөвлөлийн хурал, удирдах ажилтны зөвлөгөөнд оролцож 2019, 2020 онд гүйцэтгэсэн аудитын дүн, аудитаар илэрсэн алдаа зөрчлийг арилгах, өгөгдсөн зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллах, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зөвлөмж өгч ажиллаа. Мөн төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан цахим хуралд 2 удаа оролцож төрийн албаны ерөнхий шалгалтын комисст ажиллаа.

Төрийн аудитын байгууллагаас илрүүлж хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх асуудлын талаар шүүх, прокурор, бусад эрх бүхий байгууллагатай харилцах зорилтын хүрээнд аймгийн Прокурорын газартай хамтран ажиллах санамж бичгийг байгуулав.

Хуулийн байгууллагад шилжүүлсэн мэдээллийг бүртгэн, биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулж шүүх хуралд 5 удаа оролцож, Аймгийн Цагдаагийн газарт өмнө шилжүүлсэн асуудлын хариуг ирүүлэх албан тоот илгээж, Булган сумын нэгдсэн эмнэлэг, Гадаадын иргэн харьяатын баруун бүсийн салбар, Мөст сумын сургууль, цэцэрлэгтэй холбоотой асуудлыг АТГ, Прокурорын байгууллагад шилжүүлээд байна.

Аудиторуудын гүйцэтгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг харилцагч төсөвт болон төрийн өмчит бүх байгууллагуудын захирагч нарт гардуулан өгч Төрийн аудитын байгууллагын зорилт, үйл ажиллагааг сурталчлан аудитаар илэрсэн акт, албан



шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж чиглэлийг өгч, хэрэгжилтийг хангуулах, биелүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаарх хууль журмын заалтуудыг тайлбарлан таниулж ажиллалаа.

Мөн Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр боловсруулах үе шатанд аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж, Төсвийн тогтвортой байдлын тухай, Төсвийн тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай зэрэг хуулиудтай нийцүүлэн ажиллах санал зөвлөмж хүргүүлсэн нь шинэлэг үр дүнтэй ажил болов.

Малын тоо толгойн албан татварын тухай хууль шинээр батлагдаж, хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан сумдын төсвийн орлогын шинэ эх үүсвэрийг анхнаас нь зөв, бодитой тооцож хэвшүүлэх зорилгоор тооцоо, судалгааны аргачлал боловсруулан аймгийн СТСХ-гийн хэлтэст хүргүүлэн, Аймгийн ИТХ-ын тогтоолд тусгай заалт болгон орууллаа.


Гүйцэтгэлийн болон нийцлийн аудитыг гүйцэтгэхдээ төлөвлөлтийн үе шатанд тухайн аудитын сэдвийн хүрээнд судлах хууль эрх зүй, журам заавруудын талаар судлан хичээл бэлтгэн заах хуваарь гарган хэрэгжүүлснээр нийт аудиторуд тухайн сэдвийн талаар бүрэн мэдлэгтэй болж аудитыг хэрэгжүүлэхээс гадна аудитор бүр сургагч багшаар ажиллах мэдлэг үр чадвар эзэмшиж байна.

Аудитын тайлан дүгнэлтийг олон нийтэд сурталчлах, ил тод мэдээлэх ажлын хүрээнд 2020 оны санхүүгийн тайлангийн аудитын дүнг аймгийн ИТХТ-ын хуралдаан, танилцуулж, санхүүгийн 159, гүйцэтгэлийн 6, нийцлийн 7, нийт 172 аудитын тайлан, Ховд аймгийн 2021 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлтийг audit.mn сайтад байршуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/124 тоот тушаалаар Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудит хийх журам, 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/64 тоот тушаалаар баталсан "Хараат бус аудитын хуулийн этгээдийн хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тайлагнах заавар, аргачлал"-ын дагуу гэрээгээр санхүүгийн тайлангийн аудит хийлгэхээр байгуулсан Тунгалаг бүртгэл Аудит ХХК-ны ажлын гүйцэтгэлийг 90.5 хувьтай, Гэрэлт Хөхийн тэнцвэр Аудит ХХК-ны гүйцэтгэлийг 89.7 хувьтай үнэлж дараа жилийн санхүүгийн тайлангийн аудитад гэрээ байгуулж ажиллах боломжтой байна гэж дүгнэлээ.



Ховд аймгийн хэмжээнд 2020 оны санхүүгийн тайлангийн аудитад хамрагдах 246 байгууллагын жагсаалтыг СТАУС программд оруулан баталгаажуулж, СТА-ын журмын дагуу 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 127 тоот албан тоотор Стратеги удирдлагын газарт хүргүүлэв. .



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Үндэсний аудитын газраас ирүүлсэн баримтлах бодлого чиглэлийн дагуу 2020 оны санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөгөө боловсруулан батлуулж, аудит хийх бэлтгэл ажлыг бүрэн хангахын зэрэгцээ дараа оны санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үе шатны ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрийн аудитын газар нь санхүүгийн 239, гүйцэтгэлийн 6, нийцлийн 7, нийт 252 аудит хийж гүйцэтгэж аудитаар 50117.0 сая төгрөгийн 817 алдаа, зөрчил илрүүлж үүнээс 13099.9 сая төгрөгийн 186 алдаа зөрчлийг аудитын явцад залруулж, залруулагдаагүй зөрчлийг арилгуулахаар 323.9 сая төгрөгийн 54 төлбөрийн акт тогтоож, 28579.5 сая төгрөгийн зөрчил арилгуулах 65 албан шаардлага бичиж, 7412.9 сая төгрөгийн 498 зөвлөмж өгөгдсөн байна.

МУЕА-ын 01 тоот албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажилласнаар актын төлбөрийн биелэлт 90 хувьтай, албан шаардлагын биелэлт 92 хувьтай, зөвлөмжийн хэрэгжилт 94 хувьтай хэрэгжсэн үр дүнтэй ажиллалаа. Нийт залруулагдаагүй алдаа зөрчлийн хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

НИЙТ ЗАЛРУУЛАГДААГҮЙ АЛДАА ЗӨРЧЛИЙН ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ											
д/д	Үзүүлэлт	сая.төг									
		нийт		Биелэлт		хуульд болон хасагдсан, хэрэгсэхгүй		Оны эцсийн үлд		Хэрэгжилтийн хувь	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Төлбөрийн акт	111	670.6	74	315.7	21	285.9	16	69.0	86%	90%
2	Албан шаардлага	76	30,316.7	55	27,902.9			21	2,413.8	72%	92%
3	Зөвлөмж	523	7,963.5	472	7,514.7			51	448.8	90%	94%
НИЙТ		710	38,951	601	35,733	21	286	88	2,932	85%	92%

Өмнө онуудад 7586.1 сая төгрөгийн 12 зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн бол тайланд онд 700.8 сая төгрөгийн зөрчил бүхий 14 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, 99.6 сая төгрөгийн 3 асуудал бүрэн шийдвэрлэгдэж, 3808.1 сая төгрөгийн 6 асуудал хэрэгсэхгүй болж, 4379.2 сая төгрөгийн 17 асуудал шалгагдах шатанд байна.

Төрийн аудитын газар гүйцэтгэсэн нийт аудитын хүрээнд 22.7 тэрбум төгрөгийн үр өгөөжийг шалгагдагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлж 2020 оны нэг төгрөгт ногдох үр өгөөж 49.75 төгрөг болж өмнөх оноос 2 төгрөг 59 мөнгөөр өсөж, нийт дүнгээр 8346.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийт үр өгөөжийн тооцооллыг сүүлийн 4 жилээр харуулбал:




ГУРАВ. САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЛААР :

Төсвийн тухай хууль, Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу улс, орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит санхүүгийн тайлангийн аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан 1, сумдын нэгтгэсэн тайлан 17, улс, орон нутгийн тусгай зориулалттай сангийн 36, Төсвийн шууд захирагчийн 176, ОНӨААТҮГ-ын 10 нийт 240 байгууллагын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хамруулж, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон үндэсний стандартад нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэхийг хянаж дүгнэлт гаргав.


Санхүүгийн тайлангийн аудитад нийт 240 төсвийн захирагчийн санхүүгийн тайлан хамрагдахаас Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар батлагдсан журмын дагуу шалгуур хангасан 12 байгууллагад итгэл үзүүлж, 69 байгууллагыг түүвэрт хамруулан, 158 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргалаа. Зэвсэгт хүчний 323 дугаар анги нь татан буугдсан тул аудит хийгдээгүй болно.

Аудитад хамрагдсан байгууллагуудаас 35 орон нутгийн тусгай зориулалтын сан, 17 сумын ИТХ, ЗДТГ-ын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгаж 158 байгууллагад дүгнэлт гаргасан. Үүнээс 128 байгууллагад “Зөрчилгүй”, 29 байгууллагад “Хязгаарлалттай”, 1 байгууллагад “Сөрөг” санал дүгнэлт гаргалаа.

Хараат бус аудитын 2 компанид 25 байгууллага хуваарилан гүйцэтгүүлсэн нь нийт дүгнэлт гаргах байгууллагын 10 хувийг эзэлж байгаа ба 25 байгууллагад “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргасан байна.



Санхүүгийн тайлангийн аудитаар 658 төрлийн 22907.0 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 186 төрлийн 13099.9 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, залруулагдаагүй 9807.1 сая төгрөгийн 46 алдаа зөрчилд 273.8 сая төгрөгийн 46 төлбөрийн акт тогтоон, 38 алдаа зөрчлийг арилгуулахаар 3153.6 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлж, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахаар 385 заалт бүхий 6156.9 сая төгрөгийн зөвлөмжийг шалгагдагч байгууллагад өгч хэрэгжилтийг тооцон ажиллав.



Хууль хяналтын байгууллагад өмнөх оноос шилжиж ирсэн 3 зөрчлийн 26.6 сая, тайланд онд 8 зөрчлийн 222.8 сая төгрөгийн зөрчлийг шилжүүлж 77.1 сая төгрөгийн 1

асуудал бүрэн шийдвэрлэгдэж 26.3 сая төгрөгийн 3 зөрчил хэрэгсэхгүй болж 222.8 сая төгрөгийн 8 алдаа зөрчил хянагдах шатандаа байна.

Тайлант онд санхүүгийн тайлангийн аудитаар 273.8, өмнөх оны үлдэгдэл 57.3, нийт 331.1 сая төгрөгийн төлбөрийн актаас тайлант онд 135.3 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж бүртгэлээс 17.4 сая төгрөг хасагдаж хуулийн байгууллагад 144.3 сая төгрөгийн актыг шилжүүлж 33.6 сая төгрөгийн актын үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оноос 41 хувиар буурсан байна.

Тайлант онд СТА-аар 38 алдаа зөрчлийг залруулахаар 3153.6 сая төгрөгийн албан шаардлага бичигдэж албан шаардлагын биелэлт 100 хувь, тайлант оны 385 алдаа зөрчилд 3178.8 сая төгрөгийн зөвлөмж өгөгдөж хэрэгжилтийн хувь 100 байна.



Эх сурвалж: Ховд аймаг ТАГ-ын 2020 оны статистик мэдээ

Аймгийн хэмжээний 240 байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулах аудитыг хуульд заасан цаглаварт хугацаанд гүйцэтгэж, санхүүгийн тайлагналд илэрч байгаа алдаа зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээг хэрэгжүүлснээр дараах үр нөлөө бий болжээ. Үүнд:

- Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага, зөвлөмж өгч хэрэгжилтийг үнэлснээр төсвийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа сайжирч, төсвийн сахилга бат зохих хэмжээгээр дээшилсэн байна.
- Өмнөх оноос улсын болон орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит ААН-ийн 2019 онд “хязгаарлалтай” санал дүгнэлт 61, “сөрөг” санал дүгнэлт 4, “татгалзсан” санал дүгнэлт 1 байсан бол 2020 онд “хязгаарлалтай” санал дүгнэлт 29, “сөрөг” санал дүгнэлт 1 өгч “хязгаарлалттай” санал дүгнэлтийн тоо 32, “сөрөг” санал дүгнэлтийн тоо 3-р буурсан үзүүлэлттэй байна.
- Санхүүгийн тайлангийн аудитын 158 тайланг цахим санд байршуулж ил тод байдлыг хангаж ажиллаа.
- Ховд аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж дүгнэлт гаргаснаар аймгийн нэгдсэн төсөв бодиттой төлөвлөгдөж байна.
- ТЕЗ-ийн санхүүгийн тайланд өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласнаар ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил өмнөх оноос 40 хувиар буурч 2019 онд “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.
- Ховд аймгийн 2021 оны төсвийн орлогыг нэмэгдүүлж, зардлыг бууруулах талаар дүгнэлт гаргаж орон нутгийн орлогыг 2817.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, төсөл арга хэмжээнүүдийн төсвийг хууль, журамд нийцүүлэн оновчтой, үр ашигтай төлөвлөх шаардлагатай гэсэн дүгнэлт өгч орлогыг 27.5 хувь буюу 777.5 сая төгрөгөөр нэмэгдүүллээ.

Санхүүгийн тайлангийн аудитад 3498 хүн өдөр зарцуулж, 1908 илүү цаг ажиллаж, 3670.6 сая төгрөгийн 88 санхүүгийн үр өгөөж, 280 санхүүгийн бус үр өгөөж хүлээн зөвшөөрүүлсэн байна.

ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЛААР

Ховд аймаг дахь Төрийн аудитын газар нь 2020 онд баталсан аудитын сэдэв, төлөвлөгөөний хүрээнд 6 аудитыг төлөвлөсний дагуу бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлээр 213 аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулан аудитыг гүйцэтгэснээс нэгдсэн удирдамжаар 4, аймгийн ИТХ-ын захиалгаар 1, өөрийн санаачилгаар 1 аудитыг тус тус гүйцэтгэлээ.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар “Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “УИХ болон аймаг, сумдын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гаргах”, “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролд олгож буй өнөөгийн байдал, үр дүн” сэдэвт 4 аудит, аймгийн ИТХ-ын захиалгаар “Ховд дулааны станц төрийн өмчит хувьцаат компанийн 2018-2019 оны үйл ажиллагааны үр дүнд”, өөрийн санаачилгаар “Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт, төлөлтийн байдал”-д гүйцэтгэлийн аудитыг хэрэгжүүлэн холбогдох байгууллага, албан тушаалтанд аудитын тайланг хүргүүлээ.


Төрийн аудитын байгууллага гүйцэтгэлийн аудитаар нийт 24921.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж 20.5 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт, 23644.7 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 1255.9 сая төгрөгийн 71 зөрчилд зөвлөмж өгөгдөж, 41.9 сая төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн байна.

Тайлант онд тогтоосон 59.6 сая төгрөгийн 8 төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 8 төлбөрийн актыг хуулийн байгууллагад шилжүүлж, 17.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт, 42.3 сая төгрөгийг тухайн байгууллагын дансанд оруулсан байна.


Өмнөх оноос 1737.2 сая төгрөгийн 11 албан шаардлагыг он дамжуулан хэрэгжүүлж, 23644.7 сая төгрөгийн зөрчил арилгуулах 2 албан шаардлага өгч, нийтдээ 11 албан шаардлагын 24748.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулж, 632.5 сая төгрөгийн 2 албан шаардлагын үлдэгдэлтэй байна.

Аудитын үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэн, арвилан хэмнэлтийг бий болгох зорилгоор 1255.9 сая төгрөгийн 71 зөвлөмж шинээр өгөгдөж, өмнөх онуудын үлдэгдэл 550.6 сая төгрөгийн 25 зөвлөмжийг хэрэгжүүлснээс үзэхэд нийт зөвлөмжийн 75 хувь хэрэгжиж, 24 зөвлөмжийн хугацаа болоогүй байна.

Нийт хэрэгжүүлсэн аудитын үр дүнд 11801.0 сая төгрөгийн 41 санхүүгийн, 89 санхүүгийн бус үр өгөөжийг холбогдох байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлсэн байна.



● Эхний үлдэгдэл ● Тайлант онд нэмэгдсэн ● Хэрэгжсэн ● Хасагдсан ● Дараа онд шилжих үлдэгдэл



Эх сурвалж: Ховд аймаг ТАГ-ын 2020 оны статистик мэдээ

Төрийн аудитын тухай хууль тогтоомжийн дагуу тодорхой сэдвийн хүрээнд нэгдсэн удирдамж, ИТХ-ын захиалга, Төрийн аудитын газрын өөрийн санаачлагаар төсвийн хөрөнгийн зарцуулалт, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж шалгагдагч байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг сайжруулах асуудлыг нотлох баримтад тулгуурлан тайлагнаж, дүгнэлт зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн биелэлтийг тооцон ажилласнаар дараах үр нөлөө бий болсон байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжилтээр 41 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжихээс 32 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж тухайн жилд хүрэх зорилтот түвшнийг хангаж үр нөлөөтэй, 9 төсөл арга хэмжээ хугацаандаа хэрэгжээгүй он дамжсан, техникийн болон улсын комиссын акт, явцын хяналтаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн арилгаагүй ажлуудыг улсын комисс хүлээн авсан нь төсвийн хөрөнгийн үр дүн, үр нөлөөг бууруулж байгаад хяналт хариуцлагыг сайжруулах зөвлөмж өгч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал, үр дүн”-д хийсэн аудитын дүнд үндэслэн хүүхдийн хоол, үдийн цайны зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянахгүйгээр сарын батлагдсан хуваарийн дагуу олгож 2017-2019 онуудад 5598.8 сая төгрөгийн илүү санхүүжилт олгож, төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулсныг тогтоож дүгнэлт гаргалаа.
- “УИХ болон аймаг, сумдын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийгдсэнээр зардлын төлөвлөлт, гүйцэтгэлийн үр нөлөөнд 23.2 сая төгрөгийн хэмнэлт бий болсон байна.
- “Ховд дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар мэргэжлийн байгууллагаар зуухны ашигт үйлийн коэффициент, хүчин чадлыг тодорхойлуулан, зуухны өргөтгөл хийж, нүүрсний дутуу шаталтыг арилгах, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэн ажиллаж үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх зөвлөмж өгч ажиллаа.
- Төрийн аудитын газраас орон нутгийн татварын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр



улс орон нутгийн болон хувийн хөрөнгөөр оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, барилга байгууламжид ашиглаж байгаа түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглагч ААНБ, тухайн салбарыг хариуцан ажилладаг төрийн болон орон нутгийн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай талаар зөвлөмж хүргүүлэв.

Гүйцэтгэсэн аудитын үр дүнгийн талаар товч танилцуулбал:

4.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Ховд аймагт 2019 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 61 төсөл арга хэмжээнд 57 тэрбум 269 сая төгрөгийн санхүүжилт хийгдэхээр тусгагдсанаас Боловсролын салбарт 29.8 хувь, Эрүүл мэндийн салбарт 7.9 хувь, Хөдөө аж ахуйн салбарт 9.0 хувь, Нийгмийн хамгааллын салбарт 5.6 хувь, Төрийн үйлчилгээний салбарт 11.1 хувь, Дэд бүтцийн салбарт 33.0 хувиар тус тус тусгагджээ.



Аудит хийх явцад, хэрэгжүүлсэн ажлуудыг газар дээр нь хянахад ашиглалтад авсан байгаа болон хэрэгжих шатандаа зарим төсөл арга хэмжээнүүдийн, чанар хангалтгүй, орон нутгийн удирдлагын санал аваагүй, эрчим хүчний хэтийн бодлоготой нийцээгүй, улсын комисст хүлээлгэн өгсөн гэх боловч хүлээлгэн өгсөн актгүй, гүйцэтгэлийн материал, зураг төсөв олдохгүй зэрэгт үндэслэн “Улсын төсвийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтаар батлагдаж, төсвийн ерөнхийлөн захирагчдаас орон нутагт эрх шилжүүлэх, захиалагч үнэлгээний хороо байгуулах үе шатны хяналтууд бүрэн хийгдээгүй, тендер шалгаруулалтын хугацаа хойшлогдсноос төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна” гэж дүгнэсэн.

4.2 Улсын их хурлын сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт гүйцэтгэл , үр дүн

УИХ-ын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор СЕХ-оос аймгийн Сонгуулийн хороонд 479.1 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилж гүйцэтгэлээр 478.9 сая төгрөгийн зардал санхүүжүүлж 0.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсөвт төвлөрүүлэн, аудитаар саналын хуудас тоолох төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх зардлыг хэтрүүлэн зарцуулсан, урамшуулал илүү олгосон, хүнсний материал худалдан авсан, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх журмын хэрэгжилтийг хангах зорилгоор 7 нэр төрлийн бараа материал хуваарилагдан ирсэн үлдэгдлийг тооцоо нийлж, буцаан төвлөрүүлээгүй зэрэг алдаа зөрчлүүд гарсанд үндэслэн “Улсын төсвөөс олгох санхүүжилтийг хэрэгцээний дагуу төлөвлөн СЕХ-оос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилсан ч зарим зардлыг оновчтой төлөвлөгдөөгүй, зарим төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэйгээр зарцуулаагүй байна” гэсэн дүгнэлт өгч тайланг аймгийн онцгой комисс, сонгуулийн хорооны даргад хүргүүллээ.

4.3 Төрөөс ерөнхий боловсрол олгож буй өнөөгийн байдал үр дүн

Аудитаар аймгийн ерөнхий боловсролын сургуулийн барилга стандарт шаардлагыг бүрэн хангаагүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг зорчих шаардлага хангагдаагүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлыг бүрэн гүйцэтгээгүй, зарим сургуулиуд анги

танхим хүрэлцэхгүйгээс нэгтгэсэн, сургалтын кабинетууд болон 6 настай хүүхдийн кабинетад тавилга эд хогшил, хичээлийн хэрэглэгдэхүүн дутагдалтай, сургалтын орчин хяналтын камергүй, ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуур нөхцөлийг хангасан мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангагдаагүй, хувьсах зардлыг тооцох тогтоолыг шинэчлээгүй, хэрхэн хуваарилах талаар аргачлал байхгүйгээс төлөвлөлт алдаатай төлөвлөгдөж, сургуулиудын нормативт зардлын хэмнэлтийг бусад хүрэлцэхгүй зардалд гүйлгэн зарцуулсан, дотоод хяналтыг бүрэн хэрэгжээгүй зэрэг зөрчил илэрсэн.



Салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа зарим бодлогын баримт бичгийг сайжруулан хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, ерөнхий боловсролыг хөтөлбөр төлөвлөгөөний дагуу эзэмшүүлэн ч сургалтын чанарт дорвитой ахиц гараагүй, төсвийн төлөвлөлт бодитой бус, тусгай зориулалтын шилжүүлэг, зардлын зарцуулалтад тавих хяналт сул, төсөв хэмнэх боломжийг алдсан байна” гэсэн дүгнэлт өгөв.

4.4 Аймаг, сумын ИТХ-ын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл

Аймаг, Сумын ИТХ-ын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотойгоор СЕХ-оос аймгийн Сонгуулийн хороонд 485.6 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарилж гүйцэтгэлээр 484.5 сая төгрөгийн зардал санхүүжүүлж 1.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийг төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Аудитаар томилолт болон урамшууллын зардлыг зөрүүтэй олгосон, ХХОАТ суутгаагүй, зарим зардлыг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдүүлэлт бүрэн бус, байр тохижуулахад худалдан авсан БҮТЭЗ-ийг сумдын ИТХ-ын данс бүртгэлд бүртгээгүй алдаа зөрчил байна. Дээрх алдаа зөрчилд үндэслэн “Улсын төсвөөс олгох санхүүжилтийг СЕХ-оос ирүүлсэн аргачлалын дагуу хуваарилан өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэн, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан ч төсвийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллах шаардлагатай байна” гэсэн дүгнэлт өгөгдлөө.

4.5 Ховд Дулааны станц ТӨХК-ний 2018-2019 оны үйл ажиллагааны үр дүн



Ховд Дулааны станц ТӨХК-нийн үйлдвэрлэсэн нийт дулаан эрчим хүчний 60.1 хувийг айл өрхүүдэд түгээж байгаа боловч борлуулалтын орлогын 13.7 хувийг айл өрхөөс бүрдүүлж байгаа нь байгууллагын ашгийн үзүүлэлтийг бууруулсан, ажлын байрны тодорхойлолтод заасан боловсон хүчнээр хангагдаагүй, мэргэжлийн байгууллагаар зуухны АҮК, хүчин чадлыг тодорхойлуулан, зуухны өргөтгөл хийж, шаталтын процессыг сайжруулан ажиллах шаардлагатай, хөрөнгө, сэлбэг хэрэгслийн нөөцийн бүрдүүлэлтэд тавих хяналт сул, аюулгүй нөөцийн хадгалалт хамгаалалт хангалтгүй, тендерийг зохион байгуулахдаа хуулийн зарим заалтуудыг мөрдөөгүй, дотоод хяналт бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрч 721.0 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрч, алдаа зөрчлийг арилгах 19 зөвлөмж өгөгдсөн.

Аудитаар “Дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэн ажилласан ч стратеги төлөвлөгөө боловсруулаагүй, зуухны өргөтгөл хийх, шаталтын процессыг сайжруулах, ТУЗ нь эдийн засгийн зарим үзүүлэлтүүдийг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөөгүйгээс өр төлбөр нэмэгдэж, санхүүгийн тогтвортой байдал алдагдах эрсдэлтэй, байгууллагын дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулан ажиллах шаардлагатай байна” дүгнэлт өгөгджээ.

4.6 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр хураамжийн төлөвлөлт, бүрдүүлэлтийн үр дүн

Ховд аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 9 аж ахуйн нэгж байгаагаас үйл ажиллагаа явуулж байгаа 3 аж ахуйн нэгж байгаа ч тусгай зөвшөөрөл эзэмшигчид тусгай зөвшөөрлийн төлбөрөө хуульд заасан хугацаанд төлөөгүй, Жаргалант, Буянт, Дуут, Мөнххайрхан, Ховд зэрэг сумдын нутаг дэвсгэрт улсын болон орон нутгийн, иргэн аж ахуйн нэгжийн хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга угсралтын ажилд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалыг тооцон төлөвлөөгүй, Мянгад суманд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглаж байгаа тоосгоны үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагаас хамгийн бага тооцсон, зарим аж ахуйн нэгжид түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, хайгуул хийх тусгай зөвшөөрөл олгох талбайн байршил хэмжээг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгахгүйгээр олгосон, Дөргөн суманд түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах нөөц боломж байхгүй байхад орлогын төлөвлөгөө батлуулсан зэрэг алдаа зөрчил дутагдал байна.

Дээрх алдаа зөрчилд үндэслэн “Зарим тусгай зөвшөөрлийг газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгахгүйгээр олгосон, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашиглах, төлбөр төлөх эрх зүйн зохицуулалт хангагдсан боловч, хуулийн хэрэгжилт хангалтгүй, түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн гүйцэтгэлийн хяналт хийгдээгүй тул үр нөлөөг тооцох боломжгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт өглөө.

Гүйцэтгэлийн аудитад 368 хүн өдөр зарцуулж, 186 илүү цаг ажиллаж, 11801.0 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж, 89 санхүүгийн бус үр өгөөжийг шалгаагдагч байгууллагуудаар хүлээн зөвшөөрүүлсэн байна.

ТАВ.НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЛААР:

Нийцлийн аудитын баг 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн аудитын багуудтай хамтран ажлын уялдаатайгаар 2020 онд УАГ-ын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 6, аймгийн ИТХ-ын захиалгаар 1 нийт 7 аудитыг 314 байгууллагад цаг хугацаанд нь хийж гүйцэтгэн холбогдох тайлан мэдээг бүрэн хүргүүлж ажиллав.


Аудитын үр дүнд 29.6 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 1781.3 сая төгрөгийн 23 албан шаардлага, 29 зөвлөмж, 414.3 сая төгрөгийн 3 асуудлыг хууль хяналтын байгууллагад



шилжүүлсэн бөгөөд нийт 27 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн байна.

Нийцлийн аудитын баг 2019 онд хэрэгжүүлсэн аудитын үр дүнгээр тавигдсан 67.9 сая төгрөгийн 8 акт, 3894.3 сая төгрөгийн 48 албан шаардлага, 5125.0 сая төгрөгийн 44 зөвлөмж, хуулийн байгууллагад шилжүүлсэн 975.1 сая төгрөгийн 3 асуудлын хэрэгжилтийг хангуулахад хяналт тавьж хагас бүтэн жилээр үр дүнг тооцож ажилласнаар 6433.4 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж тооцсон болно.

2020 оны жилийн эцсийн байдлаар нийцлийн аудитаар тавигдсан албан шаардлагын биелэлт 30 хувь, зөвлөмжийн биелэлт 90 хувьтай байгаа бол хугацаа болоогүй төлбөрийн акт 4, албан шаардлага 19, зөвлөмж 12, хуулийн байгууллагад шилжсэн 3, хариуцлага тооцуулах 432 асуудал байна.



Хууль, журмын хэрэгжилтийг хангах талаар 7 нийцлийг аудитыг хуулийн хугацаанд хэрэгжүүлэн шалгагдагч байгууллагуудад тайланг хүргүүлснээр дараах аудитын үр нөлөө бий болж байна. Үүнд:

- 2020 оны орон нутгийн сонгуультай холбогдон хийгдсэн нам, эвсэл,бие даан нэр дэвшигчдийн зардлын дээд хэмжээг тогтоох, мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах, хандивын тайланг хянаж олон нийтэд мэдээлэх зэрэг багц хоорондоо уялдаа бүхий багц аудитыг гүйцэтгэж сонгуульд оролцсон улс төрийн 6 нам, 38 бие даагч, нийт 900 нэр дэвшигчдээс тайлангаа ирүүлсэн 454 нэр дэвшигчийн материалд аудит хийж холбогдох байгууллагуудад хүргүүлж нийтэд мэдээлэв.
- Нийцлийн аудитын дүнг холбогдох байгууллагуудын албан тушаалтнуудыг байлцуулан тэргүүлэх аудиторын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тушаал гарган баталгаажуулж байгаа нь зөрчил дутагдлыг давтан гаргах, засаж залруулах талаар үр дүнгээ өгч байна. Тухайлбал: 2020 оны үр дүнг 2019 онтой харьцуулбал төлбөрийн актын дүн 56.5 хувь, албан шаардлага 54.3 хувь, зөвлөмж 34.1 хувь болж тус тус буурсан байна.
- Төрийн аудитын байгууллагаас жил бүр хийгддэг шилэн дансны хуулийн хэрэгжилт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт зэрэг аудитын үр дүнд илэрч байсан алдаа зөрчлийн хэмжээ буурсан байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитын хүрээнд давтагдан гардаг зөрчлийн талаар аймгийн ИТХ, Засаг дарга түүний Тамгын газрын холбогдох хүмүүстэй хэлэлцүүлэг зохион байгуулж сангийн үр өгөөжийг дээшлүүлэх талаар аргачлал зөвлөмж хүргүүлж ажиллав.

Нийцлийн аудитын үр дүнгийн талаар товч танилцуулбал:

5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын тухай

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2015, 2016 онуудад тус бүр 2 удаа, 2017 онд 1 удаа, 2018 онд 1 удаа, 2019 онд 1 удаа аудитыг хийж гүйцэтгэн тайланг Үндэсний аудитын газарт хүргүүлэн олон нийтэд мэдээлэв.

Аймгийн хэмжээнд Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 3.1.2 -д заасны дагуу хамрагдах 205 төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнээс түүврээр 150 байгууллагыг сонгож аудитад хамруулж бусад байгууллагад итгэл үзүүллээ.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд мэдээллийн нэгдсэн цахим хуудаст бүрэн хамрагдаж хуульд заасан мэдээллийг 84.9%-тай мэдээлсэн байна.

Байгууллагуудын мэдээллийг мэдээлэх албан тушаалтан Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хоосон илгээж баталгаажуулсан нийтлэг зөрчил илэрч, аудитын явцад 0 гэсэн утгатай хоосон илгээсэн мэдээллийн 87 алдаа зөрчлийг илрүүллээ.

Төрийн аудитын байгууллагаас өмнө гүйцэтгэсэн 5 удаагийн аудитаар хуулийн 3.1.1, 3.1.2-т хамаарах байгууллагуудын хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д заасан мэдээлэл тус бүрээр гарч буй зөрчил, шалтгаан нөхцөлийг дурдаж, хэрэгжилтийн байдлыг дэлгэрэнгүй тайлагнаж хүргүүлж байсан бөгөөд Шилэн дансны тухай хууль болон холбогдох журамд нэмэлт өөрчлөлт ороогүй тул өмнөх тайланд дурдсан зөрчил хэвээр байна.

5.2 Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт, үр дүнгийн талаар

Аймгийн ОНХС-гийн төсвийг төсвөөс 5986.2 сая төгрөг, Тогтвортой амьжиргаа төслөөс 681.1 сая төгрөг, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэж бий болгосон эх үүсвэрээр 385.8 сая, төсөл хөтөлбөрөөс 450.0 сая төгрөг нийт 7921.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна


Тайлант онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнүүдэд иргэдийн санал аваагүй, зураг төсөвгүй ажлыг сонгогдсон төлөөлөгч нар өөрчилж баталснаар хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын гүйцэтгэл хангалтгүй хэрэгжиж, зориулалт бус чиг үүргээс бусад төсөл арга хэмжээнд сангийн хөрөнгийг зарцуулж байна.

Тухайн шатны дотоод аудитын нэгжээс холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийнхээ дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлээгүй, ИТХ дэргэдээ хяналтын хороо байгуулж ажиллах хяналтын чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

ОНХС-д 2019 онд 7921.9 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, зарцуулснаас аудитаар нийт 1810.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 29.6 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 1781.3 сая төгрөгийн 19 албан шаардлага, 937.0 сая төгрөгийн 30 зөвлөмжийг аудитын тайлангаар тус тус хүргүүллээ.

5.3 Орон нутгийн 2020 оны сонгуультай холбоотой багц аудитын талаар.

Орон нутгийн 2020 оны ээлжит сонгуульд оролцох улс төрийн 6 намын хандивын тайланг хуулийн хугацаанд хүлээн авч дүгнэлт гаргаж аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлж audit.mn сайтаар мэдээлэв.



Аймаг сумдын ИТХ оролцсон 5 намаас 3 нам зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан ирүүлж 2 нам ирүүлээгүй байна. Нийт 900 нэр дэвшигчдээс 454 нэр дэвшигч тайлангаа ирүүлснийг нэгтгэж тайлан дүгнэлтийг аймгийн Сонгуулийн хороо болон СТСХ-д хүргүүлж, 1 сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, 2 сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалтыг нийтэд нээлттэй мэдээллээ.

Орон нутгийн сонгуульд оролцох 6 нам 38 бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт орсон зорилт арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэх болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцэж байгаа эсэх талаар дүгнэлтийг хуулийн хугацаанд гаргаж аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлж нийтэд мэдээллээ.

5.4 Бичил уурхайн хууль тогтоомжийн хэрэгжилтийн аудитын талаар:

Ховд аймагт Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын судалгаагаар тусгай зөвшөөрөлтэй 8.0 га талбайтай ашиглалтын 22, 545.4 мян га талбайтай хайгуулын 78 лизенц байгаа бөгөөд нийт нутгийн 7.3 хувийг хамарсан 553.3 мянган га талбайд 100 тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Аймгийн хэмжээнд бичил уул уурхайгаар ашигт малтмал олборлох журмын дагуу авч хэрэгжүүлсэн ажлын хүрээнд хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагаа болон уул уурхайн ашиглалтын улмаас 7 сумын 37 байршилд 160 га талбай эвдрэлд орсон талаарх урьдчилсан судалгаа байна. Үүнээс 2016-2017 оны хооронд орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн байгууллагуудын санхүүжилтээр нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагаар 65 орчим га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийлгэсэн мэдээ байгаа боловч эвдэрсэн газар дээр нь ажиллаж, хэмжилт хийх, мэдээлэл цуглуулах, бодит тоон мэдээтэй болох, судалгааг нарийвчлан гаргаагүй байна.


Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагууд нь “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Ашигт малтмалын тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Газрын хэвлийн тухай” хуулийн дагуу уурхайн олборлолт явагдаж дууссан талбайд эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэн хүлээлгэж өгөх үүрэг хүлээдэг бөгөөд одоогийн байдлаар олборлолтын ажил дуусаж хүлээлгэн өгсөн талбай байхгүй байна.

Нийцлийн аудитад 336 хүн өдөр зарцуулж, 140 илүү цаг ажиллаж, 6433.4 сая төгрөгийн 6 санхүүгийн үр өгөөж, 23 санхүүгийн бус үр өгөөж хүлээн зөвшөөрүүлсэн байна.

ЗУРГАА. ДОТООД АЖЛЫН ТАЛААР:

Байгууллагын 2020 онд зохион байгуулах дотоод сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэн жилийн байдлаар 11 ажилтан цахим болон удаагийн арга зүйн сургалт, удирдах ажилтны зөвлөгөөний мэдээллийн сургалтыг тус тус зохион байгууллаа.

Прокурорын газраас Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулиудаар сургалт зохион байгуулсан нь аудиторудын хууль, эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд ач холбогдолтой арга хэмжээ болж, 3 удаагийн зөвлөгөө мэдээлэл авч хамтран ажиллаа.



Ажилтнуудаас 1 албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлүүлэхээр нэмэлт санхүүжилтийн данснаас 10.0 сая төгрөг зарцуулах хүсэлтийг Үндэсний аудитын газарт уламжилж шийдвэрлүүлэв.

Үндэсний аудитын газраас зохион байгуулсан “Удирдах ажилтны зөвлөгөөн, сургалт”-д байгууллагын дарга тэргүүлэх аудитор оролцож нийт ажилтнуудад агуулга тус бүрээр сургалт зохион байгууллаа. Мөн ахлах аудиторуд Удирдлагын академийн ахлах түшмэлийн 40 цагийн мэргэшүүлэх багц, нийт аудиторуд хуулийн мэдлэг олгох сургаалтанд хамрагдаж амжилттай суралцлаа.

Статистикийн хэлтсээс статистик тоо мэдээллийг үндэс суурь болгох тоон үзүүлэлтийн ашиглалт, хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор “*Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn*” сайтыг ашиглах талаарх сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтаар аудитад шаардлагатай тоо, мэдээллийг хүснэгт болон график хэлбэрээр, англи, монгол хэлээр цахим сайтаас цаг алдалгүй түргэн шуурхай авснаар аливаа бодлого шийдвэрт дүгнэлт гаргах, төлөвлөлт, судалгаанд дүн шинжилгээ хийх чухал ач холбогдолтой сургалт боллоо.

Байгууллагын албан хаагчдын мэргэжлийн сургалтын хэрэгцээ шаардлагын судалгааг гаргаж, төрийн аудитын байгууллагаас 2020 онд зохион байгуулах сургалтын судалгааг Стратегийн удирдлагын газрын сургалт хариуцсан ажилтанд хүргүүлснээс гадна, Үндэсний аудитын газраас зохион байгуулсан арга зүйн болон шинэчилсэн стандартуудыг ойлгох онлайн сургалтуудад нийт албан хаагчид СТАУС, абль программаар бүрэн хамрагдаж өгөгдсөн сургалт, заавар, гарын авлагыг өдөр тутмын ажилдаа ашиглаж байна.

Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хууль тогтоомж, зааварт нийцүүлэн гүйцэтгүүлэх зорилгоор ирсэн, явсан бичгийн бүртгэл, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Тэргүүлэх аудиторын тушаал 45, байгууллагад ирсэн бичиг 250, явуулсан бичиг 503, дарга, тэргүүлэх аудиторын зөвлөлийн хурал 17 удаа хуралдаж 25 асуудлыг шийдвэрлэн, аппарат 21 удаа хуралдаж цаг үеийн асуудлыг хэлэлцжээ.

Үндэсний аудитын газар болон бусад байгууллагуудаас 250 албан бичиг ирснийг хүлээн авч хэрэгжүүлэн, хугацаатай 33 бичиг, 1 байгууллага, 7 иргэнээс ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэсэн болно.

Дотоод журамд зааснаар дагуу нийт албан хаагчдыг санхүүгийн тайлангийн дараа эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд бүрэн хамрууллаа.

Байгууллагын хэмжээнд уламжлагдсан ажил болох цагаан сарын үеэр тэтгэвэрт гарсан ахмадуудаа, хүүхдийн баяраар ажиллагчдынхаа 16-аас доош насны хүүхдүүдийг хүлээн авч гарын бэлэг гардууллаа.

Ковид-19 цар тахалын нөхцөл байдалтай уялдуулан 2 удаагийн тушаалаар хөрөнгө шийдвэрлэж, албан хаагчдыг витаминжуулах, нэг удаагийн маск, бээлий, гар ариутгагч зэргээр хангаж ажиллав.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаар дамжуулан ахлах аудитор Д.Нарантуул, аудитор Д.Балжинням нарыг Төрийн дээд шагнал алтан гадас одонгоор, аудитор Д.Эрдэнэцэцэгийг Хөдөлмөрийн хүндэт медалиар, ахлах аудитор Д.Мөнхтулгыг Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан цол тэмдгээр Үндэсний аудитын газарт уламжилсан боловч шагналууд шийдэгдээгүй байна.

Байгууллагын сервер, сүлжээ, компьютерын мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллаж албан хэрэгцээнд ашиглаж байгаа 11 компьютерт вирусийн программыг Үндэсний аудитын газрын мэдээлэл технологийн ажилтны зааварчилгаагаар суулган тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааг ханган ажиллаж байна.

Нийт албан хаагчид аудиторуудад ёс зүйн хэм хэмжээг сахих, ашиг сонирхлын зөрчилд орохгүй байх, гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх талаар удирдлагын зүгээс анхааран прокурорын газартай хамтран сургалт зохион байгуулан ажиллаж байна.

Монгол улсын Ерөнхий аудитораас болон ҮАГ-ын хэлтэс, газруудаас өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр биелүүлэн ажиллахын зэрэгцээ байгууллага хамт олны санаачилгаар дараах ажлуудыг шинээр хэрэгжүүлэн орон нутгийн төрийн албан хаагчдыг манлайлан, үлгэр дуурайл болж ажиллалаа. Үүнд:

Байгууллагын соёл, хамт олны нэгдмэл байдлыг бэхжүүлэн багаар ажиллах чадварыг дээшлүүлэх зорилгоор санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудит болон захиргаа аж ахуй хариуцсан 4 баг болж хуваагдан байгууллагын нийт ажилчдыг хамруулан сар бүр 1 шинэлэг ажил зохион байгуулан ажиллаа. Энэхүү ажлын хүрээнд захиргаа аж ахуйн баг нь сэтгэл зүйч багш У.Чулуунчимэгээр “Хувь хүний хөгжил-Сэтгэл зүйн боловсрол” сэдвээр сургалт ярилцлага, Санхүүгийн аудитын баг ажилчдын дунд “АХА” танин мэдэхүйн уралдаан, “Хамт олноо хэн сайн мэдэх вэ” асуулт хариултын уралдаан, Гүйцэтгэлийн аудитын баг ажилтан албан хаагчдын ар гэрийн нөхцөл, зан чанарыг хөгжилтэй байдлаар танин мэдэх уралдаан тэмцээнүүд тус тус зохион байгуулав. Харин Нийцлийн аудитын баг нь Ковид-19 цар тахалтай холбогдуулан аймгийн онцгой комисст нэг удаагийн 300ш маск хүлээлгэн өгч цар тахлаас урьдчилан сэргийлэх сургалтын талаарх сургалтыг байгууллагын хамт олонд зохион байгууллаа. Нийт хамт олныг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх арга хэмжээг хавар, намарт 2 удаа зохион байгуулж ажиллав.



Сайн үйлсийн аянд хамт олноороо нэгдэж 2020 онд шинээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн 16-р цэцэрлэгийн үйл ажиллагааг дэмжиж хүүхдүүдэд тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүнийг хүлээлгэн өгч, Эрдэнэбүрэн сумын харьяат иргэн Ц.Цагаанцоожийн эмчилгээний зардалд хамт олноосоо хандив цуглуулан дэмжлэг үзүүллээ. Мөн төрийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байсан ахмад настнуудад 2 удаа хүндэтгэл үзүүлэн ажилчид өөрсдөө халуун хоол, аарц, чацаргана чанаж ахмадуудаа эргэж ахмадуудаас туршлага, судлан ажиллаа.



ДОЛОО. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР.

2020 оны эхний хагас жилийн байдлаар 452.9 сая төгрөгийн санхүүжилт авах төлөвлөгөөтэйгөөс 455.4 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд Үндэсний аудитын газраас 2.5 сая төгрөгийг нэмж шийдүүлэн нийт 3 компьютер 1 принтер шинээр худалдан авлаа.

Байгууллагын 2021 оны төсвийн хязгаарын болон төсвийн төслийн саналыг боловсруулан 2020 оны 04 сарын 27-ны өдрийн 50 дугаар албан тоотоор Үндэсний аудитын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн.

Мөн 2021 оны төсвийн төслийг plan.unicus.mn программд оруулж, нэгтгүүлэн ажиллаа.

Төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж, Үндэсний аудитын газарт хүргүүлэн, нэгтгүүлж, ил тод мэдээллийн самбарт сар, улирлын хуваарь, гүйцэтгэлийн мэдээг байршуулж, Шилэн дансны хуулийн дагуу цахимд тогтмол мэдээлж хэвшсэн болно.

НАЙМ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Төрийн аудитын газрын хамт олон Монгол Улсын Ерөнхий аудитортой байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэн, аймгийн Төрийн аудитын газраас дэвшүүлсэн зорилтын хүрээнд байгууллагын 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлуудыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Төрийн аудитын газрын албан хаагчид аудитын үе шатанд бүрд аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэн, аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахаар анхааран ажилласны үр дүнд залруулагдаагүй алдаа зөрчлийг арилгаж, шалдаа зөрчил дахин давтан гарах эрсдэл буурсан үзүүлэлттэй байна.

Төрийн аудитын байгууллагын жигд ажиллагааг хангах, аудитын чанар үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын үйл ажиллагаанд тулгарч буй асуудлыг шийдвэрлэж, ажлын ололтыг нэвтрүүлэх зорилгоор дараах саналыг хүргүүлж байна.

1. Ажилтнуудын ажиллах нөхцөлийг ая тухтай ажиллах нөхцөлийг хангах үүднээс байгууллагын албан тасалгаануудын урсгал засварыг хийх шаардлагатай байгаа тул хөрөнгийн асуудлыг 2021 оны төсөвт тусган шийдвэрлэж өгөх
2. Өнөөдрийн ашиглагдаж байгаа компьютеруудын ашиглагдах хугацаа нь дуусаж хурд, багтаамжаараа шаардлага хангахгүй байгаа тул боломжийн түвшинд шинэчлэх арга хэмжээ авах
3. Цар тахлын хорио тавигдаж үйл ажиллагаа хэвийн болсон тохиолдолд аудиторуудын гадаад болон дотоодын сургалт зохион байгуулж мэргэшүүлэх тал дээр анхаарах зэрэг асуудлуудыг уламжилж байна.

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЦАХИМ САЙТ: AUDIT.MN

ЦАХИМ ХАЯГ: KHOVD@AUDIT.GOV.MN

Холбоо барих утас: 70433061, 70432545

